

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашигладаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.



Шалгалт, туршилт

1. Үрийг хүлээлгэн өгөх үед шалгаж хүлээн авна. Шалгах үед зөвлөрсөн, няцарсан, ялзарсан, өвчилсөн байвал нийлүүлэгч өөрийн зардлаар ялгаж цэвэрлэж зөрүү жинь тоо хэмжээгээр акт үйлдэж хохирлыг үрээр болон тендерт нийлүүлэх санал болгосон мөнгөн дүнгийн зөрүүгээр хохирлыг барагдуулна.
2. Нийлүүлэхээр санал болгож буй үрийн дээжийг Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторын байгууллагад шинжлүүлж чанар, стандартын шаардлага хангасан эсэх талаарх шинжилгээний дүн, түүнд үндэслэсэн таримал ургамал үр, хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж ирүүлсэн байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Монгол улсын байгаль, цаг уур, хөрсний шинж чанар, онцлогт тохирч нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан дүйцэх тэмсний үр байх ба эрт болон дунд эртийн сортын нийлүүлнэ.
2. Нийлүүлэх тэмсний үр нь MNS-3223-2006 стандартын шаардлагыг хангасан байна.
3. Тендерт оролцогчийн санал болгосон үрийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, зураг, сертификат г.м/ ирүүлнэ.
 - a. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанарын шаардлага хангаж байгааг нотлох а) барааны гарал үүсэл, б) чанар в) ургамал хорио цээрийн гэрчилгээний хуулбарыг албан ёсны орчуулгын товчоогоор орчуулуулж ирүүлнэ.
 - b. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанар, стандартын шаардлага хангасан эсэх талаарх Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторын байгууллагын шинжилгээний дүн, түүнд үндэслэсэн таримал ургамлын үр, хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж ирүүлнэ.
 - c. Гадаад орноос болон дотоодын нийлүүлэгдэх үрийн үйлдвэрлэгч нь Тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон үр үргүүлэх эрх бүхий хуулийн этгээд байх ба энэ тухай баримт, нотолгоо ирүүлнэ. Албан ёсны орчуулгатай байна.
 - d. Нийлүүлэх тэмсний үрийн талбайд хянан баталгаа хийгдсэн байна. Энэ тухай баримт нотолгоо ирүүлнэ.
 - e. Тарих үрийн технологи, зөвлөмж, үйлдвэрлэгчийн танилцуулга



Техникийн тодорхойлолтын шаардлага үзүүлэлт

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

№	Үзүүлэлт	Нийлүүлэгчийн тодорхойлолт
1.	Ерөнхий үзүүлэлтүүд Таримлын нэр: - Сортын нэр: - Гарал үүсэл: - Үйлдвэрлэсэн он /2024 он /	
2.	- Таримлын сорт: Монгол улсад нутагшсан болон ирээдүйтэй сортын үр байна. - Үрийн чанарын шаардлага: Үрийн төмс, сортын ба тариалалтын чанар, техникийн шаардлага MNS-3223:2006 стандартын шаардлагыг хангасан байна.	
Элит үр		
3	1. Гадаад байдал: Бүтэн, эрүүл, хуурай, болц гүйцсэн, цэвэр, уг сортын хэлбэр дурс, шинж чанарыг бүрэн хадгалсан байна. - Гонзгой булцуутай сортын голч 35-55 мм - Бөөрөнхий булцуутай сортын голч 45-65 мм - булцууны жин- гр 40-100 2. Төмсний өвчин - Фитофтор 0,5 - Хар цахтай 1,3 - Нунтаг цахтай 1,0 - Цагирган илжрэл 0 - Энгийн цахтай гадаргуугийн 1/3 ээс дээш 1,0 - Хуурай илжрэл 0,5 - Нойтон илжрэл 0 - Иш харлах 0 - Махлаг эдийн толбожилт, харлалт 2,0 - Дүгэрэг хорхой 0 - Төмөрлөг толбожилт махлаг эдийн харлалт 2,0	
Нийлүүлэгдэх үрийн үйлдвэрлэгч нь үр үржүүлэх эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөлтэй байна.		
4	- Үр тус бүрийг Савлагaa 10 кг-аар уутанд савлаж, нийлүүлэгчийн гарал үүсэл, компаний хаяг, утасны дугаарыг заавал тодоор бичиж наасан байна. - Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт: Нийлүүлэгч барааг Улаанбаатар хотод зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслэлээр тээвэрлэн авчирч зориулалтын хөргүүртэй агуулахад хадгалж Захиалагчид хүлээлгэн өгөх ба Захиалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийн дагуу эцсийн хүлээн авагчид барааг хүлээлгэн өгч дуусгана.	